

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баян-Овоо сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

АУДИТЫН КОД: ӨМА-2022/9/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Өмнөговь аймаг Даланзадгад сум 2022 он	Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: С.Цэрэнбаяр Утас: 70533552 Цахим хаяг: Tserenbayars@audit.gov.mn Аудитын менежер: Т.Хонгорзул Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn Аудитор Т.Хишигбат Утас: 70533552 Цахим хаяг: Khishigbatt@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу

Нэг. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баян-Овоо сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь төр, эдийн засаг, нийгмийн бодлогын удирдлагын үйл ажиллагааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллага юм.

Хоёр. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

/сая төгрөгөөр/

Санхүүгийн байдлын тайлан		
	Үзүүлэлт	2021.12.31
	Эргэлтийн хөрөнгийн дүн	4.9
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	13.4
	Нийт хөрөнгийн дүн	18.3
	Нийт өр төлбөрийн дүн	
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	18.3
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	18.3
Санхүүгийн үр дүнгийн тайлан		
	Үйл ажиллагааны орлогын дүн	73.8
	Үйл ажиллагааны зардлын дүн	74.7
	Үйл ажиллагааны үр дүн	-0.9
	Үйл ажиллагааны бус үр дүн	-1.4
	Үйл ажиллагааны нийт үр дүн	-2.3
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	20.6
	Тайлант оны үр дүн	-2.3
	Эцсийн үлдэгдэл	18.3
Мөнгөн гүйлгээний тайлан		
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	72.7
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	72.7
	Үйл ажиллагааны ЦМГ	
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	65.9
	Урсгал зардал	65.9
	Хөрөнгийн зардал	
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	65.9
	Улсын төсвөөс санхүүжих	
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	65.9

Гурав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэлс

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ								

Дөрөв. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээлэлд 150 мэдээлэл оруулахаас 16 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 зүгээр зүйлийн 4.1 “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална”, 4.1.3 “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 7 дугаар зүйлийн 7.1 “Шилэн дансны мэдээллийг энэ хуулийн дагуу иргэн олон нийтэд хүргэх үүргийг дараах албан тушаалтан хүлээнэ” дахь заалтуудтай нийцэхгүй байна.

Тав. Аудитын үр дүн

5.1 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

[illegible]

4	ТТЗ										
5	ТЕЗ										
	НИЙТ	5	1.7	1	0.1			1	0.7	3	1.0

5.2 Аудитын илрүүлэлт: /Илрүүлсэн алдаа, зөрчлийн товч утга, түүнийг шийдвэрлэсэн байдал /хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал, залруулсан алдаа, төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж//

Аудитаар нийт 1.7 сая төгрөгийн 5 алдаа зөрчил илэрснээс, 0.1 сая төгрөгийн 1 алдааг залруулж, хууль тогтоомж хэрэгжүүлж ажиллах 0.7 сая төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, 1.0 сая төгрөгийн алдаа зөрчилд 3 зөвлөмж өглөө.

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

Орлого үр дүнгийн тайланг мөнгөн гүйлгээний тайлантай тулган баталгаажуулахад бичиг хэргийн зардал 42,000 төгрөг, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардал 42,000 төгрөгийн зөрүүтэй байна.

Албан шаардлага:

Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж зардлаас 674,500 төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Зөвлөмж:

Шилэн дансны мэдээлэлд 150 мэдээлэл оруулахаас 16 мэдээллийг хоцруулсан байна. Тус байгууллагын үндсэн хөрөнгийн тайланд үлдэх өртөггүй 2 ширхэг бүртгэлтэй байна. Төсвийн хэмнэлтийн горимыг зөрчиж хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлаас 1.0 сая төгрөгийг сургалт зохион байгуулахад зарцуулсан байна.

Зургаа. Аудитын санал дүгнэлт



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2022-02-22 № 117
танай _____-ны № _____-т

БАЯН-ОВОО СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Г.ГАНЦЭЦЭГ ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны Баян-Овоо сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баян-Овоо сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

С.ЦЭРЭНБАЯР